


Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн
2012 оны 6-дугаар сарын
20-өдрийн хурлаар батлав



**Шарын гол ХК-ийн ХЭ-ийн хурал
хуралдуулах журам**

**Улаанбаатар хот
2012 он**

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлбэр, түүнийг хуралдуулах этгээд
4. Хурлын зар хүргэх, саналын хуудас, тооллогын комисс, хурлын шийдвэр
5. Хурлын шийдвэр ба хурлын тэмдэглэл

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ХЭХ-ын эрх зүйн хэм хэмжээ, бүрэн эрх, хурлын хэлбэр, түүнийг зарлах, хуралдуулах журам, хэлэлцэх асуудал, шийдвэр гаргах журам, саналын хуудас, ХЭ-ээс хуралд оролцох хэлбэр тэдгээртэй холбоотой харилцааг тогтооход оршино.
- 1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

2. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: Үүнд:
 - 2.1 компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 2.2 нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 2.3 компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 2.4 компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 2.5 компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 2.6 хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 2.7 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 2.8 хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
 - 2.9 компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.10 ТУЗ-ийн саналыг үндэслэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 2.11 компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
 - 2.12 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 2.13 төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлбэр, түүнийг хуралдуулах этгээд

- 3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр хуралдуулна.
- 3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг заана. Үүнд:
 - 3.3.1 хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
 - 3.3.2 хурлын хэлэлцэх асуудал;
 - 3.3.3 хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;

- 3.3.4 хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
- 3.3.5 саналын хуудасны агуулга;
- 3.3.6 хурлын дарга;
- 3.3.7 тооллогын комиссын дарга, гишүүд.
- 3.4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.
- 3.5 Ээлжит хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг заавал хэлэлцэж батлана.
- 3.6 ТУЗ нь энэ журмын 3.2-д заасан шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй.
- 3.7 Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:
 - 3.7.1 төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 3.7.2 төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
 - 3.7.3 компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 3.7.4 компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
 - 3.7.5 төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
 - 3.7.6 компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

Дөрөв. Хурлын зар хүргэх, саналын хуудас, тооллогын КОМИСС

- 4.1 ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хурал хуралдах шийдвэр гарсан өдрөөс хойш 5 хоногийн дотор СЗХ-оос гаргасан журмын дагуу нийтэд мэдээллэхээс гадна гэрээт брокерын пүүсүүдэд хүргүүлж цаашдаа ХЭ-д мэдээлэх, тэдгээрээс санал авах ажлыг зохион байгуулна.
- 4.2 Хурлын зард компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг зэрэг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.
- 4.3 Хурлаас гаргах шийдвэрийн төсөлд Саналын хуудсаар санал авах ба түүнийг хурлын зарын хамт ХЭ-д хүргүүлнэ.
- 4.4 Саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсонд тооцно. Саналын хуудсын нийтлэг загварыг хавсралтаар үзүүлэв.
- 4.5 ХЭХ хуралдуулах шийдвэрт тухайн хурлаар хэлэлцэх асуудалтай уялдуулан саналын хуудсын загварыг батлан ХЭ-д хүргүүлэнэ.

- 4.6 Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана:
- 4.6.1 компанийн оноосон нэр
 - 4.6.2 хурал хуралдах газар, өдөр, цаг
 - 4.6.3 хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо, ХЭ-ийн регистрийн болон хувьцаа эзэмшигчийн бүртгэлд бүртэгэсэн бүртгэлийн дугаар;
 - 4.6.4 санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 4.6.5 хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төслийг "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" хэрэв татгалзсан бол саналаа өгөх бололцоог тусгасан хүснэгт
 - 4.6.6 саналын хуудсыг бөглөх тайлбар
- 4.7 Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 4.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудалд энгийн нэг хувьцаа эзэмшигч саналын нэг эрхтэй байна.
- 4.9 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
- 4.10 Төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхээс өмнө төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх бөгөөд түүний итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй байна.
- 4.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 4.12 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно.
- 4.13 Тухайн хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр Тооллогын комисс саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлно.
- 4.14 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-өөс тогтоосон хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй.
- 4.15 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр нь ТУЗ-өөс тогтоосон өдөр байна.
- 4.16 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилно.
- 4.17 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:
Үүнд:
- 4.17.1 хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;
 - 4.17.2 тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;
 - 4.17.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;
 - 4.17.4 санал өгөх журмыг тайлбарлах;
 - 4.17.5 санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;

- 4.17.6 санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;
- 4.17.7 санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;
- 4.17.8 санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;
- 4.17.9 саналын хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.
- 4.18 хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.
- 4.19 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст хурал хуралдуулахтай холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

Тав. Хурлын шийдвэр ба хурлын тэмдэглэл

- 5.1 ХЭХ-ын шийдвэрийг тооллогын комиссийн тогтоолыг үндэслэн гаргана.
- 5.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүн, гаргасан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдэгдэнэ.
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.
- 5.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд дараахь мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 5.4.1 хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;
 - 5.4.2 хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 5.4.3 хурлаар хэлэлцсэн асуудал;
 - 5.4.4 хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;
 - 5.4.5 саналын хуудас хэрэглэсэн бол уг саналын хуудасны загвар;
 - 5.4.6 хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол.
- 5.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 5.6 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ХЭХ-ын хуралдуулах тухай шийдвэр, хурлын зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичгүүд болон хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэл зэрэг хурал хуралдуулахтай холботой бүх материалыг хурал бүрээр тусгай хавтас нээж хадгалах ба ХЭ болон бусад шаардлагатай этгээдийн хүсэлтээр үзүүлэх үүрэгтэй.
- 5.7 ХЭХ хуралдсны дараа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын шийдвэрийн талаар ХЭ-д мэдээлэл хүргэх үүрэгтэй.

ооооОООооо

Жишээ загвар

.... Төлөөлөн удирдах зөвлөлийн 20..
оны дүгээр тогтоолын хавсралт

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх
асуудлаар хувьцаа эзэмшигчдээс
САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог

нэр

регистрийн дугаар

ХЭ-ийн бүртгэлийн дугаар

эзэмшиж буй хувьцааны төрөл

тоо.....

Ээлжит хурал 20.. оны дүгээр сарын-ны өдрийн

цагаасд болно.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсө Н	Татгалзса Н	Түдгэлзсэн	Санал
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны ажлын тайланхангалттай гэж үзэх		+		Хангалтгүй гэж үзэх
2.	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт					
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг сонгох = Ердийн гишүүн	1.А. Бөлд 2. 3. 4. 5. 6.		+		Д.Галт
	= Хараат бус гишүүн	7. Д. Сүрэн 8.	+			

4.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 20.. оны төсвийг батлах	9.				
5..	Ногдол ашиг хувиарлаагүй тухай танилцуулга	Шийдвэрийн төслийг нь бичих Шийдвэр гарахгүй				

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр дүгээр сарын болно.

Хувь эзэмшигчийн гарын үсэг

...

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон
Тооллогын комиссын дарга

Гишүүд:

.....

хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

Ар талд нь энэхүү саналын хуудсыг бөглөх зааврыг бичих